

2-р ангийн Математикийн хичээлийн хөтөлбөр

Хичээлийн сэдэв: - “Хамтарч хурдан бодъё”

Зорилго: - Үржүүлэх үйлдлийг таниулах

Зорилт: - Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг олох

- Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг үржвэр хэлбэрээр тэмдэглэх, бичих

Хэрэглэгдэхүүн: - Хэрчмэл үзүүлэн, ТӨМ, зураг, дүрс, анги орчны бодит зүйлс

Хичээлийн явц:

Үе шат	Багшийн үйл явц	Суралцагсдын үйл явц	Анхаарах зүйл
Сэргээн санах үе 2 мин	- Багш самбарт дүрс, тэмдэг байрлуулна. 1.  +  +  = 2.  +  +  = -Дүрсүүдээр бодлого зохиож бодуулна. - Хоёр дахь загварын дагуу дэвтэртээ тус бүр 2 жишээ зохиож бичээрэй. - Зохиосон жишээг ажиглуулж ямар шинж чанартай байгааг хэлүүлнэ.	Сурагчид дүрсийн оронд тоо бичиж бодлого зохиож бодно. 1. $2 + 3 + 4 =$ 2. $4 + 4 + 4 =$ X1: $5 + 5 + 5 =$ X 2: $3 + 3 + 3 =$ X3: $7 + 7 + 7 =$ гэх мэт X1: 3 нэмэгдэхүүнтэй байна. X2: Бүх нэмэгдэхүүн ижил байна.	- Ижил дүрсийн оронд ижил тоонууд байна. -Аль болох өмнөх зохиосноос өөр жишээ зохиохыг чиглүүлж өгнө.
Сэдэлжүүлэх үе ... мин	-Хүүхэд бүрт 8 ш алимны дүрс тарааж өгнө. \улаан, ногоон, шар\ - 8 алимьг тэнцүү тоогоор өрөх даалгавар өгнө. -Алимьг хэд хэдээр өрсөн бэ? - Үүнийгээ + үйлдэл ашиглан яаж бичих вэ? -Энэ олон ижил нэмэгдэхүүнийг дараалан нэмэхэд хурдан байна уу? Удаан байна уу? Хариу нь түргэн гарах уу? - Ижил хэмэгдэхүүнүүдийн нийлбэрийг хурдан боддог өөр үйлдэл байдаг юм байна.	-Алимуудыг өрж тавина.              1. $2 + 2 + 2 + 2 =$ 2. $4 + 4 =$ 3. $1 + 1 + 1 + 1 + 1 + 1 + 1 + 1 =$ - Нэг бүрчлэн нэмэхэд удаан байна. - Хэцүү байна.	-Тэнцүү тоогоор багцалж өрөхийг тайлбарлаж өгнө. -Хариуг тавихгүйг сануулна. -Олон үйлдлийг нэг үйлдлээр илэрхийлж болдгийг сануулна.

	Өнөөдөр бүгдээрээ “Хамтарч хурдан бодъё”		
Хөгжүүлэх үе мин	Одоо тэгвэл энэ бодлогуудаа хялбар аргаар бодъё. -Хэдийг хэдэн удаа нэмсэн байна вэ? -Үржүүлэх үйлдлийн тэмдгийг танилцуулна. -Хоёр янзаар тэмдэглэдгийг хэлж өгнө. * - дэвтэрт х – сурах бичиг дээр ингэж тэмдэглэдэг Бодлогыг уншуулна.	2-ыг 4 удаа 4-ийг 2 удаа 1-ийг 8 удаа нэмсэн байна. $4 * 2 = 8$ $2 * 4 = 8$ $8 * 1 = 8$ Үржигдэхүүн - 4 Үржигдэхүүн – 2 Үржвэр – 8 2 – г 4 удаа нэмэхэд 8 гарна. 4-ийг 2 дахин авахад 8 гарна. 1 –ийг 8-аар үржүүлэхэд 8 гарна	Ижил нэмэгдэхүүнүүдийн тоо нь 1-р үржигдэхүүн болно, ижил нэмэгдэхүүн нь 2-р үржигдэхүүн болно Нийлбэр нь үржвэр болно. нэмэх, үржих үйлдлийн гишүүдийг ялгаж тайлбарлана.
Бататгал мин	-Нэг ширээнд хэдэн хүүхэд сууж байна вэ? -Тэгвэл 1салаанд хэдэн хүүхэд сууж байгааг олоорой. - Манай анги хэдэн сурагчтай вэ?	X1: 2,2-оороо X2: $2+2 +2+2+2=10$ гэж олно. X3: 5 ширээ байгаа учир ширээ бүрд 2 хүүхэдтэй учир $5 * 2=10$ гэж бодож олно. X4: 3 эгнээ ширээ байна.Эгнээ бүрд 10 хүүхэд байгаа. $10 + 10 +10 =30$ X5: $3 * 10 = 30$	3 янзаар уншуулна.
Дүгнэлт мин	-Сурагчдад хэрчмэл ТӨМ тарааж өгнө. 1. Нийлбэрийг үржвэр болгох 2. Үржвэрийг нийлбэр болгох илэрхийллүүдийг төрлөөр нь ангилж байрлуулна. -Бодох аргыг дүгнэж яриулна. / уншуулна./ а. 1-р баганад байгаа бодлогуудыг яаж бодсон байна вэ? б. 2-р баганад байгаа бодлогуудыг яаж бодсон байна вэ?	1. $4 + 4 + 4 = \square * \square = \square$ 2. $3 * 6 = \square + \square + \square = \square$ -Бодлогыг ижил төстэйгээр нь баганачилж байрлуулна.	Бие
	- Хүүхэд тус бүрийг болон анги нийтийг аман үнэлгээгээр	-Өөрийг нь өөрөөр нь, найзыг нь найзаар нь үнэлүүлнэ.	

Үнэлгээ мин	үнэлнэ.		
-------------------------	---------	--	--